



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 23 (596)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- *Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Дотоо хоног тутмын хэвтэл

2009 оны зургадугаар сарын 17 № 23 (596)

Улаанбаатар хот

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |     |
|------|--|-----|
| 290. | Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай   | 487 |
| 291. | Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай | 488 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 292. | Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай   | Дугаар 34 | 488 |
| 293. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай | Дугаар 40 | 490 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |   |            |     |
|------|---|------------|-----|
| 294. | О.Зандрааг Шүүхийн сахилгын хорооны даргаар томилох тухай     | Дугаар 113 | 490 |
| 295. | Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай | Дугаар 114 | 490 |
| 296. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай                       | Дугаар 115 | 490 |

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 297. | Журам батлах тухай   | Дугаар 43 | 491 |
| 298. | Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, зардлын төсөв батлах тухай        | Дугаар 44 | 493 |
| 299. | Төрийн өмчит компани байгуулах тухай   | Дугаар 45 | 495 |
| 300. | Зөвлөл байгуулах тухай   | Дугаар 48 | 495 |
| 301. | Ой тэмдэглэх тухай   | Дугаар 50 | 496 |
| 302. | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай                                       | Дугаар 56 | 496 |
| 303. | Тооны дээд хязгаар тогтоох тухай   | Дугаар 57 | 496 |
| 304. | 2009 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай | Дугаар 59 | 497 |

### Тав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 305. | Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай | Дугаар 14 | 499 |
|------|--|-----------|-----|

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ

2009 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

### ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тариалангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 15<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

борлуулалтын дундаж үнийг харгалзан мөнгөн урамшуулал олгож болно.

“15<sup>1</sup> дүгээр зүйл. Төрөөс тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих

15<sup>1</sup>.2. Энэ хуулийн 15<sup>1</sup>.1-д заасан мөнгөн урамшууллын хэмжээг Засгийн газар тогтооно.”

15<sup>1</sup>.1.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, хуулийн этгээдэд тэдгээрийн улсад болон гурилын үйлдвэрт нийлүүлсэн буудайн нэг тонн тутамд тухайн жилийн зах зээлийн

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДСОН ГЭЖ ҮЗЭЖ БҮРЭН ЭРХИЙГ НЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Гучин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 41 дүгээр зүйлийн 2-4 дэх хэсэгт заасныг үндэслэн

Цахиагийн Элбэгдоржийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

### Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолыг 2009 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 34 дүгээр тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Их Хурлын гишүүний төрийн албанд баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлж, төрийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хувийн ашиг сонирхлын нөлөөлөөс хамгаалах, төр, олон нийтийн итгэлцлийг бэхжүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Монгол Улсын Их Хурлын гишүүн /цаашид "Гишүүн" гэх/ нь үйл ажиллагаандаа энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг баримтлахын зэрэгцээ Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хэм хэмжээг дагаж мөрдөнө.

**Хоёр. Албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ**

2.1. Гишүүн нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн хуулийг дээдлэн сахих, аливаа асуудалд шударга байр сууринаас хандах, бусдын нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг

сонирхлыг хүндэтгэх зарчмын хүрээнд дараахь ёс зүйн хэм хэмжээг баримтална:

2.1.1. бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг нь эрхэмлэн, хүндэтгэлтэй хандах;

2.1.2. хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төр, олон нийтийн холбоог бэхжүүлэх;

2.1.3. бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүлээн авсан нууцад хамаарах аливаа мэдээлэл, бичиг баримттай танилцахдаа нууцын талаархи хууль тогтоомжийг баримтлах;

2.1.4. төрийн байгууллагын албан хаагчаар зөвхөн албаны чиг үүрэгт нь хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлж байх;

2.1.5. Төрийн ордон болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхимд биеэ зөв авч явж, холбогдох хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2.1.6. хууль зөрчсөн шударга бус явдалтай эвлэрэхгүй байх;

2.1.7. ёс зүйн хэм хэмжээг сахих талаар олон нийтэд үлгэр жишээ үзүүлэгч байх.

**Гурав. Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ёс зүйн хэм хэмжээ**

3.1. Гишүүн нь нийт иргэн, төр, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, хэнийг ч ялгаварлан



гадуурхахгүй байх зарчмын хүрээнд дараахь ёс зүйн хэм хэмжээг баримтална:

3.1.1. төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн нөөц болон мэдээллийг зөвхөн албан ажлын хэрэгцээнд ашиглах;

3.1.2. бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улстай холбоотой аливаа асуудлаар гадаадын байгууллага, албан тушаалтанд амлалт өгөхгүй байх;

3.1.3. албан тушаалын байдлаа гэр бүлийнхээ болон хувийн санхүүгийн байдлыг дээшлүүлэхэд ашиглахгүй байх;

3.1.4. албан тушаалын үүрэг хариуцлагатай нь харшилсан санхүү, худалдааны болон бусад ижил төстэй ямар ч хэлбэрийн хэлэлцээрт оролцохгүй байх;

3.1.5. төрийн өмч, үйлчилгээ болон мэдээлэл /ажил үүргийн дагуу олж авсан мэдээлэл, мөн өөрийн ажил үүрэгт холбогдолгүй ч албан тушаалынхаа хүрээнд олж авсан мэдээлэл/-ийг хууль бусаар ашиглахгүй байх.

3.2. Гишүүн аливаа аж ахуйн нэгж, байгууллагын болон санхүүгийн нөлөөнд автахгүй байх, албаны эрх, үүргээ хувийн зорилгоор ашиглахгүй байх үүднээс холбогдох хууль тогтоомжийг мөрдөх бөгөөд дараахь үйлдэл хийхийг хориглоно:

3.2.1. бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа өөрийн нэр хүнд, эрх мэдлийг ашиглан үнэт цаас, эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулах, бусдад нөлөөлөх оролдлого хийх;

3.2.2. бүрэн эрхийнхээ хүрээнд асуудал боловсруулж шийдвэрлэх болон хууль ёсны шийдвэр гаргахад нь бусдад нөлөөлөх;

3.2.3. албан тушаалын хувьд ижил зэрэг зиндааны болон өөрт нь захирагддаг, эсхүл үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг албан тушаалтанд хууль бусаар нөлөөлөхийг оролдох;

3.2.4. албан тушаалынхаа байдлыг ашиглаж хууль бус орлого, ашиг хонжоо, давуу тал олох зорилготой бусад үйлдэл хийх.

3.3. Гишүүн хууль тогтоомжоор хориглосон аливаа ажил, албан тушаал эрхлэх, түүнчлэн цалин хөлс, урамшуулал авах, өгөхийг шаардахыг хориглоно.

3.4. Гишүүн шийдвэр гаргах асуудлаар өөрийн болон гэр бүлийн гишүүний хувьд ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл санал хураалтад оролцохоос сайн дураар татгалзах бөгөөд энэ тухайгаа Ёс зүйн дэд хороонд мэдэгдэнэ.

**Дөрөв. Хөрөнгө, орлогын мэдүүлэг, албан томилолттой холбогдсон ёс зүйн хэм хэмжээ**

4.1. Гишүүн хууль тогтоомжид заасан хугацаа, журмын дагуу хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв гаргах үүргээ сахин биелүүлнэ.

4.2. Гишүүн хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөний дагуу улс төрийн намд-сонгууль албан тушаал эрхлэх, сургалт, эрдэм шинжилгээний ажил хавсран гүйцэтгэснээс олох орлогын хэмжээ нь гишүүний жилийн үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байвал зохино.

4.3. Гишүүн иргэдийн боловсролыг дээшлүүлэх, оюуны хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор яриа хийх, илтгэл тавих, өгүүлэл, ном бичсэнийхээ төлөө урамшуулал авч болох бөгөөд энэхүү орлогоо хөрөнгө, орлогын мэдүүлэгт заавал тусгана.

4.4. Гишүүн гадаад, дотоодод томилолт, аялалаар явахдаа эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг гаргуулах ба удирдамж, чиглэлийг чанд баримтална.

**Тав. Шагнал, бэлэг дурсгал хүлээн авахтай холбогдсон ёс зүйн хэм хэмжээ**

5.1. Гишүүн нь Улсын Их Хурлын гишүүний нэр хүндэд харш үйлдэл хийхгүй байх зарчмын хүрээнд дараахь ёс зүйн хэм хэмжээг баримтална:

5.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон медаль, төрийн бусад шагнал авахгүй байх;

5.1.2. Улсын Их Хурлын удирдлагын зөвшөөрөлгүйгээр аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн зөвлөл, иргэнээс аливаа өргөмжлөл, шагнал авахгүй байх;

5.1.3. албан үргээ хэрэгжүүлснийхээ төлөө болон хийж гүйцэтгэхээр төлөвлөж байгаа ажлын төлөө иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх, хууль бусаар бусад бэлэг авах, хангамж эдлэхгүй байх;

5.1.4. эрх мэдлийнхээ хүрээнд хянан шалгаж байгаа байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан журмаас гадуур бэлэн мөнгө болон мөнгөөр үнэлэгдэх үнэт зүйлс авахгүй байх.

**Зургаа. Сонгуулийн сурталчилгааны ажлын үеэр баримтлах ёс зүйн хэм хэмжээ**

6.1. Гишүүнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан олгосон ажлын байр, санхүүгийн эх үүсвэр, холбоо, мэдээлэл, тээврийн хэрэгсэл, төрийн өмчийн бусад эд зүйлийг сонгуулийн сурталчилгааны ажилд ашиглахыг хориглоно.

**Долоо. Бусад**

7.1. Энэ дүрмийн биелэлтэд Ёс зүйн дэд хороо хяналт тавин ажиллах бөгөөд уг дэд хорооны ажиллах журмыг тусгай дүрмээр тогтооно.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийн товыг 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 12 цаг 06 минутад байхаар тогтоосугай.

1.Цахиагийн Элбэгдорж Монгол Улсын

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

**О.Зандрааг Шүүхийн сахилгын хорооны даргаар томилох тухай**

Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь: Оросоогийн Зандрааг Шүүхийн сахилгын

хорооны даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

**Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай**

Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь: Намжилсүрэнгийн Оюунтуяаг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Цэдэвийн Отгонжаргалыг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд, Бавалын Баатарыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн

шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд, Ендонгийн Цогтзанданг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус сэлгэн ажиллуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

**Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Шүүхийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4 дэх заалтыг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Ламжавын Ганболдыг Өмнөговь аймгийн шүүхийн

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 02 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Н.Алтанхуяг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

1. "Алтанбулаг худалдааны чөлөөт бүсэд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, оршин суух журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД** **Н.АЛТАНХУЯГ**

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД** **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2009 оны 43 дугаар тогтоолын хавсралт

### "АЛТАНБУЛАГ" ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСЭД МОНГОЛ УЛСЫН ИРГЭН, ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАЛАЛГҮЙ ХҮН ЗОРЧИХ, ОРШИН СУУХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс (цаашид "Чөлөөт бүс" гэх)-д Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, оршин суухтай холбогдсон харилцааг Чөлөөт бүсийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Иргэний бүртгэлийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон энэхүү журмаар зохицуулна.

1.2. Монгол Улсын иргэний Чөлөөт бүсэд зорчих, оршин суух харилцааг зохицуулах, бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг Чөлөөт бүс дэх иргэний бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан ажилтан эрхлэн явуулна.

1.3. Чөлөөт бүсэд зорчих, оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүний зөвшөөрөл, бүртгэл, тэдгээрт хяналт тавих ажиллагааг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын Сэлэнгэ аймаг дахь албаны чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтан (цаашид "Чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтан" гэх) эрхлэн явуулна.

#### Хоёр. Монгол Улсын иргэн Чөлөөт бүсэд зорчих, оршин суух

2.1. Монгол Улсын иргэн дараахь баримт бичгийн аль нэгийг ашиглан Чөлөөт бүсэд зорчино:

2.1.1. Монгол Улсын иргэний үнэмлэх;

2.1.2. Монгол Улсын иргэн 16 нас хүрээгүй бол төрсний гэрчилгээ;

2.1.3. Гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн бол гадаад паспорт;

2.1.4. Албан ажлын зайлшгүй шаардлагаар Чөлөөт бүсэд нэвтрэх төрийн албан хаагч ажлын газрын үнэмлэх;

2.1.5. Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас олгосон нэвтрэх эрхийн үнэмлэх;

2.1.6. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан ажлын газрын үнэмлэх.

2.2. Монгол Улсын иргэний баримт бичгийн хугацаа дууссан, хүчингүй болсон тохиолдолд Чөлөөт бүсэд нэвтрүүлэхгүй.

2.3. Монгол Улсын иргэн Чөлөөт бүсэд оршин суух зөвшөөрлийг Чөлөөт бүсийн захирагч олгоно.

2.4. Чөлөөт бүсэд оршин суух зөвшөөрөл хүсэгч Монгол Улсын иргэн Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд дараахь баримт бичгийг бүрдүүлэн өгнө:

2.4.1. оршин суух зөвшөөрөл хүссэн өргөдөл;

2.4.2. иргэний үнэмлэхийн хуулбар;

2.4.3. гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн бол үндэсний энгийн гадаад паспортын хуулбар;

2.4.4. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах буюу хөдөлмөр эрхэлж байгаа тухай албан ёсны тодорхойлолт;

2.4.5. зураг (3.5x4.5) 2 хувь.

2.5. Захирагчийн ажлын алба хүсэлтийг ажлын 4 хоногт багтаан шийдвэрлэнэ.

2.6. Чөлөөт бүсэд оршин суух хугацааг тухайн иргэний уг бүсэд үйл ажиллагаа явуулах хугацаатай уялдуулан тогтооно.

2.7. Чөлөөт бүсэд орсон, гарсан, оршин суух байгаа Монгол Улсын иргэний бүртгэл, шилжих хөдөлгөөний бүртгэлийг уг бүс дэх иргэний бүртгэл, мэдээллийн ажилтан эрхэлнэ.

2.8. Чөлөөт бүсэд оршин суух зөвшөөрөлтэй иргэний эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхэд болон шууд асрамжид байгаа эцэг, эх, 18 насанд хүрсэн боловч гэрлээгүй хүүхдийг түүний нэгэн адил бүртгэнэ.

2.9. Иргэний бүртгэлд овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, хүйс, регистрийн дугаар, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, эсхүл гадаад паспортын дугаар, Монгол Улсад оршин суугаа хаяг, Чөлөөт бүсэд орсон, гарсан огноо зэрэг мэдээллийг тусгаж, мэдээллийн санд оруулна.

2.10. Чөлөөт бүс дэх иргэний бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан ажилтан нь Монгол Улсын иргэний гэр бүлийн байдлын, хүн амын ерхийн, иргэний үнэмлэхийн, үндэсний энгийн гадаад паспортын болон шилжих хөдөлгөөний талаархи иргэний бүртгэлийг хөтөлж, холбогдох тайлан мэдээг гаргаж, зохих журмын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт ирүүлж байна.

## Гурав. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Чөлөөт бүсэд зорчих, оршин суух

3.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Чөлөөт бүсэд зорчихдоо хүчин төгөлдөр гадаад паспорт буюу түүнийг орлох баримт бичигт виз авах бөгөөд уг виз нь зөвхөн тухайн Чөлөөт бүсэд үйлчилнэ.

3.2. Чөлөөт бүсэд виз олгох хялбарчилсан журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаалаар батална. Хилийн шалган нэвтрүүлэх боомтод Чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтан виз олгож, "чөлөөт бүс" гэсэн тэмдэглэл хийж, визийн тэмдэг, дугаарыг дарж, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

3.3. Монгол Улсад орох, орох-гарах визтэй гадаадын иргэн, харьяалалгүй хүн Чөлөөт бүсэд зорчихдоо визийн хүчинтэй хугацаанд дахин виз авах шаардлагагүй.

3.4. Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн, харьяалалгүй хүн оршин суух зөвшөөрлийн хугацаанд Чөлөөт бүсэд визгүй зорчих болно.

3.5. Монгол Улстай иргэд харилцан визгүй зорчих талаар гэрээ, хэлэлцээр байгуулсан гадаад улсын иргэн гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд Чөлөөт бүсэд визгүй зорчино.

3.6. Чөлөөт бүсэд оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэн, харьяалалгүй хүн Чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтанд дараахь баримт бичгийг бүрдүүлэн өгнө:

3.6.1. оршин суух зөвшөөрөл хүссэн хүсэлт;

3.6.2. Чөлөөт бүс дэх хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллагаас олгосон хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл;

3.6.3. гэр бүлийн гишүүн бол гэрлэлтийн баталгааны хуулбар;

3.6.4. хүүхдийн төрсний гэрчилгээ буюу түүнийг орлох баримт бичгийн хуулбар;

3.6.5. хүчин төгөлдөр паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичиг;

3.6.6. зураг (3.5x4.5) 2 хувь.

3.7. Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба ажлын 4 хоногт багтаан хүсэлтийг шийдвэрлэнэ.

3.8. Чөлөөт бүсэд оршин суух зөвшөөрлийг сунгах хүсэлтийг уг оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас 5-аас доошгүй хоногийн өмнө энэ журмын 3.6-д заасан баримт бичгийг бүрдүүлэн Чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтанд гаргана.

3.9. оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн, харьяалалгүй хүний эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхэд болон шууд асрамжид байгаа эцэг, эх, 18 нас хүрсэн боловч гэрлээгүй хүүхдийг түүний нэгэн адил бүртгэнэ.

3.10. Чөлөөт бүсэд 31-90 хоногийн хугацаагаар зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүн Чөлөөт бүсэд нэвтэрснээс хойш ажлын 7 хоногт багтаан Чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтанд бүртгүүлж, буцахдаа бүртгэлээс хасуулна.

3.11. Чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтан гадаадын иргэний паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичигт "зөвшөөрөл" гэсэн дардас дарж, бүртгэлийн дугаар, олгосон он, сар, өдөр, зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа, чөлөөт бүсийн нэрийг бичиж, эрх бүхий ажилтан гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулан, бүртгэлийг мэдээллийн санд оруулна. Бүртгэлээс хасахдаа паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичигт "хасав" гэсэн дардас дарж, зохих тэмдэглэл хийнэ.

3.12. Чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтан гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн асуудлаар дараахь чиглэлээр дэлгэрэнгүй мэдээг нэгтгэн долоо хоног, сар, улирал, хагас, бүтэн жилээр тайлан гаргаж, тухай бүр Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газарт хүргүүлнэ:

3.12.1. гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз олгосон мэдээ;

3.12.2. Чөлөөт бүсэд зорчсон болон оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл;

3.12.3. захиргааны арга хэмжээ авагдсан болон гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүний талаархи мэдээ.



## Дөрөв. Бусад зүйл

4.1. Хууль тогтоомж, дүрэм журам болон энэхүү журмыг зөрчсөн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын Улсын байцаагч, гадаадын иргэн, харьяатын бүртгэл, зөвшөөрөл, визийн хяналтын Улсын байцаагч Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу тус тус хариуцлага ногдуулна.

4.2. Чөлөөт бүсэд зорчих, оршин сууж байхдаа зөрчил гаргаж захиргааны арга хэмжээ авагдсан болон гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүний талаархи мэдээллийг эрх бүхий байгууллага зохих журмын дагуу тухай бүр харилцан солилцоно.

4.3. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар захиргааны зөрчил давтан гаргасан, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Чөлөөт бүс болон Монгол Улсаас албадан гаргах, Чөлөөт бүсэд тодорхой хугацаагаар нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авах тухай саналаа зохих журмын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдад тавьж шийдвэрлүүлнэ.

4.4. Чөлөөт бүсийн асуудал хариуцсан ажилтан, Чөлөөт бүс дэх Иргэний бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан ажилтан дангаар болон Чөлөөт бүс дэх хяналтын бусад байгууллагуудтай хамтран Чөлөөт бүсэд зорчигч, оршин суугч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүний бичиг баримтад шалгалт хийж болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 02 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

**Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, зардлын төсөв батлах тухай**

Эрчим хүчний тухай хуулийн 8.7-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

/гурван зуун жаран хоёр сая хоёр зуун дөчин мянган/ сая төгрөгөөр тус тус баталсугай.

Эрчим хүчний зохицуулах газрын эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2009 оны эхний хагас жилд авах зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хавсралтын ёсоор, тус газрын 2009 оны эхний хагас жилийн зардлын төсвийг 362.24

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

**Засгийн газрын 2009 оны 44 дугаар тогтоолын хавсралт**

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДЭЭС 2009 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД АВАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

| № | Тусгай зөвшөөрөл эзэмшигчид                   | Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ (сая төг) |
|---|---|---|
| 1 | "Дулааны II цахилгаан станц" ХК               | 10.11   |
| 2 | "Дулааны III цахилгаан станц" ХК              | 60.36   |
| 3 | "Дулааны IV цахилгаан станц" ХК               | 139.94  |
| 4 | "Дарханы дулааны цахилгаан станц" ХК          | 20.42   |
| 5 | "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ХК       | 17.71   |
| 6 | "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ХК        | 7.89  |
| 7 | "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ХК    | 1.50  |
| 8 | "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК | 12.93   |
| 9 | "Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ" ХК    | 25.21   |





|    |   |       |
|----|---|-------|
| 10 | "Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК                   | 7.65  |
| 11 | "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ХК                    | 8.90  |
| 12 | "Багануур, зүүн өмнөт бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ХК        | 6.40  |
| 13 | "Улаанбаатарын дулааны сүлжээ" ХК                               | 11.03 |
| 14 | "Дарханы дулааны сүлжээ" ХК                                     | 2.38  |
| 15 | "Багануурын дулааны станц" ХК                                   | 2.26  |
| 16 | "Налайхын дулааны станц" ХК                                     | 1.36  |
| 17 | Баянхонгор аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ОНӨЦТК                | 0.40  |
| 18 | Хөвсгөл аймгийн "Хөвсгөл эрчим хүч" ОНӨХХК                      | 0.47  |
| 19 | Увс аймгийн "Улаангом-цахилгаан түгээх сүлжээ" ХХК              | 0.19  |
| 20 | Ховд аймгийн "Ховд-цахилгаан түгээх сүлжээ" ХХК                 | 0.20  |
| 21 | Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар              | 0.20  |
| 22 | Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" ХХК                           | 13.16 |
| 23 | Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам" | 1.11  |
| 24 | Улаанбаатар хотын "Эрчим сүлжээ" ХХК                            | 0.08  |
| 25 | Улаанбаатар хотын "Нолго" ХХК                                   | 0.05  |
| 26 | Улаанбаатар хотын "Ар Жанар" ХХК                                | 0.20  |
| 27 | Улаанбаатар хотын "Ашид-Ундрах" ХХК                             | 0.27  |
| 28 | Улаанбаатар хотын "Батбаян бүрд" ОНӨҮГ                          | 0.19  |
| 29 | Улаанбаатар хотын "Ганга-өргөө" ОНӨҮГ                           | 0.15  |
| 30 | Улаанбаатар хотын "ГМ" ХХК                                      | 0.40  |
| 31 | Улаанбаатар хотын "Дулаан Өргөө" ХХК                            | 0.34  |
| 32 | Улаанбаатар хотын "Ивэн-Эх" ХХК                                 | 0.16  |
| 33 | Улаанбаатар хотын "Опен хаус" ХХК                               | 0.23  |
| 34 | Улаанбаатар хотын "Өнөр горхи" ХХК                              | 0.36  |
| 35 | Улаанбаатар хотын "Өнөр хотхон" ХХК                             | 0.37  |
| 36 | Улаанбаатар хотын "Санкомфорт" ХХК                              | 0.38  |
| 37 | Улаанбаатар хотын "Санни Хаус" ХХК                              | 0.72  |
| 38 | Улаанбаатар хотын "Сансар-Өргөө" ХХК                            | 0.28  |
| 39 | Улаанбаатар хотын "СИМС" ХХК                                    | 0.20  |
| 40 | Улаанбаатар хотын "Толгойт-Инк" ХХК                             | 0.24  |
| 41 | Улаанбаатар хотын "Хайрхан Уул-Өргөө" ХХК                       | 0.41  |
| 42 | Улаанбаатар хотын "Хаусинг сервис" ХХК                          | 0.44  |

|     |  |        |
|-----|--|--------|
| 43  | Улаанбаатар хотын "Хөх-Асар" ХХК                       | 0.78   |
| 44  | Улаанбаатар хотын "Эма энд Би" ХХК                     | 0.33   |
| 45  | Улаанбаатар хотын "Эцэг-Эх хүү" ХХК                    | 0.17   |
| 46  | Улаанбаатар хотын "Ганбиж" ХХК                         | 0.08   |
| 47  | Улаанбаатар хотын "Багануур-Ус" ОНӨҮГ                  | 0.19   |
| 48  | Орхон аймгийн "Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК | 0.36   |
| 49  | Орхон аймгийн "Эрдэнэт-Амьдрал" ОНӨХХК                 | 0.22   |
| 50  | "Эрчим хүчний диспетчерийн үндэсний төв" ХХК           | 2.86   |
| Дүн |  | 362.24 |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 02 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

### Төрийн өмчит компани байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.5, Компанийн тухай хуулийн 1.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохиох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх үүрэг бүхий "Мон-Атом" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсугай.

2. "Мон-Атом" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн санг бүрдүүлэхэд шаардлагатай 100.0 (нэг зуун) сая төгрөгийг Монгол

Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган шийдвэрлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

3. Компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, үйл ажиллагааг нь зохих журмын дагуу эхлүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), Цөмийн энергийн газрын дарга С.Энхбатад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ДОЛГОР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 02 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

### Зөвлөл байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, салбар хоорондын уялдааг сайжруулах, нэгдсэн бодлогоор хангах чиг үүрэг бүхий гадаадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах асуудал эрхэлсэн орон тооны бус

зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай:

Дарга - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Гишүүд: - Гадаад харилцааны сайд;

-Хүний эрхийн үндэсний комиссын дарга (зөвшилцсөнөөр);

-Сангийн дэд сайд;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд

сайд;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд

сайд;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 -Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
 -Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дарга.  
 Нарийн бичгийн дарга -Зөвлөлийн Ажлын албаны дарга

2. Зөвлөлийн Ажлын албаны орон тооны хязгаарыг 6 хүртэл байхаар тогтоож, тус албаны ажилтныг төрийн албан хаагчийн хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт харьяалуулсугай.

3. Зөвлөлийн ажиллах журмыг баталж

мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгорт даалгасугай.

4. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсвийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт тусган санхүүжүүлж байх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Б.ДОЛГОР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2009 оны 02 дугаар  
сарын 11-ний өдөр**

**Дугаар 50**

**Улаанбаатар  
хот**

**Ой тэмдэглэх тухай**

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 370 жилийн ойг 2009 оны 10 дугаар

сарын 29-ний өдөр тэмдэглэсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД** **Е.ОТГОНБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2009 оны 02 дугаар  
сарын 18-ны өдөр**

**Дугаар 56**

**Улаанбаатар  
хот**

**Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цэргийн дүйцүүлэх албыг 2009 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 2.3 (хоёр сая гурван зуун мянган) сая төгрөг байхаар тогтоосугай.

2. Мөнгөн төлбөрийн зарцуулалтад хяналт

тавьж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Батлан хамгаалахын сайд Л.Болд нарт, мөнгөн төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД** **Л.БОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2009 оны 02 дугаар  
сарын 18-ны өдөр**

**Дугаар 57**

**Улаанбаатар  
хот**

**Тооны дээд хязгаар тогтоох тухай**

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2009 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД** **Л.БОЛД**



## Засгийн газрын 2009 оны 57дугаар тогтоолын хавсралт

### 2009 онд ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

| №    | Аймаг, нийслэл | Тооны дээд хязгаар |
|------|----------------|--------------------|
| 1    | Архангай       | 80                 |
| 2    | Баян-Өлгий     | 80                 |
| 3    | Баянхонгор     | 50                 |
| 4    | Булган         | 30                 |
| 5    | Говь-Алтай     | 60                 |
| 6    | Говьсүмбэр     | 10                 |
| 7    | Дархан-Уул     | 35                 |
| 8    | Дорноговь      | 35                 |
| 9    | Дорнод         | 50                 |
| 10   | Дундговь       | 25                 |
| 11   | Завхан         | 30                 |
| 12   | Орхон          | 15                 |
| 13   | Өвөрхангай     | 70                 |
| 14   | Өмнөговь       | 40                 |
| 15   | Төв            | 80                 |
| 16   | Увс            | 50                 |
| 17   | Сүхбаатар      | 50                 |
| 18   | Сэлэнгэ        | 35                 |
| 19   | Ховд           | 50                 |
| 20   | Хөвсгөл        | 70                 |
| 21   | Хэнтий         | 30                 |
| 22   | Улаанбаатар    | 85                 |
| Бүгд |                | 1060               |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

### 2009 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн 2009 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заагаагүй салбар болон шашны байгууллагад гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчийн 5 хүртэл хувь, гадаад болон дотоодын төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газар, хүмүүнлэг, тусламжийн байгууллага болон гадаадын аж ахуйн нэгж,

байгууллагын төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг нийт ажиллагчдын 30 хүртэл хувь байхаар тус тус баталсугай.

3. Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Т.ГАНДИ**





|   |             |              |  |  |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|---|-------------|--------------|--|--|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|
| M |             |              | МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ<br>УХААН БОЛОН ТЕХНИКИЙН<br>ҮЙЛ АЖИЛЛАГАА                    |  |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|   | 72          |              | Шинжлэх ухааны эрдэм<br>шинжилгээ, ололт, судалгааны<br>үйл ажиллагаа            | 30   | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| N |             |              | ЗАХИРГААНЫ БОЛОН<br>ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ<br>АЖИЛЛАГАА                             |  |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|   | 791         |              | Аялал, жуулчлалын агентлаг,<br>аяллын операторын үйл<br>ажиллагаа                | 10   | 15 | 20 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 |    |    |    |    |
| P | 85          |              | БОЛОВСРОЛ  |  |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|   | 851,852,854 |              | Бага болон бүрэн дунд, бусад<br>боловсрол олгох үйл ажиллагаа                    | 40   | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 |
|   | 853         | 8522<br>8530 | Техник, мэргэжлийн дунд<br>боловсрол болон дээд<br>боловсрол олгох үйл ажиллагаа | 30   | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| O |             |              | ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БА<br>НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА                                    |  |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|   | 86          |              | Хүний эрүүл мэндийн үйл<br>ажиллагаа   | 5  | 6  | 7  | 6  | 7  | 8  | 7  | 8  | 9  | 8  | 9  | 10 |    |    |    |    |
|   | 87          |              | Оршин суугчдад үзүүлэх<br>халамжийн үйл ажиллагаа                                | 20   | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 |
|   | 88          |              | Зориулалтын байргүй нийгмийн<br>тусламжийн үйл ажиллагаа                         | 20   | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 |
| R |             |              | УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ<br>НААДАМ  |  |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|   | 90          | 900          | 9000   | Бүтээл туурвих, урлаг, үзвэр<br>үйлчилгээний үйл ажиллагаа   | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  |
|   | 93          |              | Спорт, зугаа цэнгэл, чөлөөт<br>цагийн үйл ажиллагаа                              | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  |
| S |             |              | ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ҮЙЛ<br>АЖИЛЛАГАА  |  |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|   | 95          |              | Хувийн болон өрхийн<br>хэрэглээний бараа,<br>компьютерийн засвар,<br>үйлчилгээ   | 5  | 6  | 7  | 6  | 7  | 8  | 7  | 8  | 9  | 8  | 9  | 10 |    |    |    |    |
|   | 96          | 960          | Хувийн үйлчилгээний бусад үйл<br>ажиллагаа                                       | 5  | 6  | 7  | 6  | 7  | 8  | 7  | 8  | 9  | 8  | 9  | 10 |    |    |    |    |
| U |             |              | ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА,<br>СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ<br>АЖИЛЛАГАА                  |  |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|   | 99          | 990          | 9900   | Олон улсын байгууллага, суурин<br>төлөөлөгчийн үйл ажиллагаа | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 |

Жич: 20 хүртэлх монгол ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагад гадаадын 1 иргэн байж болно.

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 91 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг нэг мөр  
ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор  
Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн  
1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн

15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага  
болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Хүнийг санаатай алах гэмт хэрэг нь бусдын  
амь насыг хохироход чиглэсэн санаатай үйлдэл

/эс үйлдэхүй/ хийсний улмаас хүн нас барсан бөгөөд гэмт үйлдэл, амь хохирогчийн үхэл хоёрын хооронд шалтгаант холбоотой байх шинжийг заавал агуулна.

Хүнийг санаатай алах гэмт хэрэг нь шууд болон шууд бус санаатай үйлдэгдэнэ.

2. Амь хохирогч нас барсан үеэс эхлэн хүнийг санаатай алсан үйлдлийг төгссөн гэмт хэрэг гэж үзнэ.

Хүнийг санаатай алах гэмт хэргийг зүйлчлэхэд амь хохирогч хэзээ /тэр даруйдаа, эсхүл хэсэг хугацааны дараа/ нас барсан болох нь нөлөөлөхгүй.

3. Хүнийг санаатай алахад чиглэсэн үйлдэл /эс үйлдэхүй/-т хийсэн боловч гэмт этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас хохирогч нас бараагүй бол хүнийг санаатай алах гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэж үзнэ.

Энэхүү гэмт хэрэг зөвхөн шууд санаатай үйлдэгдлэгийг анхаарвал зохино.

4. Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т заасан хүндрүүлэх болон мөн хуулийн 92, 93, 94 дүгээр зүйлд заасан хөнгөрүүлэх нөхцөл байдалгүйгээр, түүнчлэн энэ хуулийн 40 /Аргагүй хамгаалалт/, 41 /Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах/, 42 /Гарцаагүй байдал/ дугаар зүйл, 44 дүгээр зүйлийн 44.1 /Гушаал, захирамж биелүүлэх/-д заасан нөхцөл байдлаас бусад тохиолдолд хүнийг санаатай алсан үйлдлийг мөн зүйлийн 91.1-д зааснаар зүйлчилнэ.

5. Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсгийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

5.1. Гэмт этгээдийн үйлдэл нь уг хэсэгт заасан хоёр ба түүнээс дээш хүндрүүлэх шинжүүдийг нэгэн зэрэг агуулж байвал аль тохирох заалтуудыг давхар хэрэглэн зүйлчилнэ.

Энэ тохиолдолд шүүх гэмт үйлдлийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлын талаар эрх зүйн үнэлгээ өгөхөөс бус тухайн хэслийн заалт тус бүрээр ял оногдуулахгүй.

5.2. "Шунахайн сэдэлт" гэдэгт гэмт этгээд өөртөө болон бусад этгээдэд эдийн буюу эдийн бус баялаг олж авах, эсхүл ямар нэгэн үүргийг гүйцэтгэхээс зайлсхийх гэсэн санаа зорилгыг ойлгоно.

Уг сэдэлт нь гэмт хэрэг үйлдэхээс өмнө үүссэн байдгийг анхаарвал зохино.

Шунахайн сэдэлтээр хүнийг санаатай алсан гэмт үйлдлийг Эрүүгийн хуулийн өмчлөх эрхийн

эсрэг гэмт хэрэг гэх мэт бусад зүйл, хэсгээр давхар зүйлчлэх шаардлагагүй.

Бусдыг санаатай алсны дараа эд хөрөнгийг авсан гэмт үйлдлийг шунахайн сэдэлтээр алсан гэж үзэхгүй.

5.3. "Танхайн сэдэлт" гэж нийгэмд тогтсон эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээ, уламжлагдан ирсэн зан заншлыг үл тоомсорлон, өөрийн ичгүүр сонжуургүй, догшин зан авир, бүдүүлэг үйлдлээ бусдын анхаарлын төвд байлгахыг эрмэлзэх, ямар ч шалтгаангүй, эсхүл ялимгүй зүйлийг шалтаг болгосныг хэлнэ.

Танхайн сэдэлт нь бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, нийгмийн хэв журмыг ноцтой зөрчих зэрэг хэлбэрээр илэрнэ.

"Нийгмийн хэв журам", "нийгмийн хэв журмыг ноцтой зөрчсөн", "бусдыг илтэд үл хүндэтгэх", "догшин авирлах", "хүч хэрэглэх", "хүч хэрэглэхээр заналхийлэх" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолд зааснаар ойлгож хэрэглэнэ.

Хүнийг танхайн сэдэлтээр санаатай алахын өмнө, эсхүл дараа нь танхайрах гэмт хэргийг үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилнэ. Мөн энэ тохиолдолд танхайрах гэмт хэргийн улмаас үүссэн үр дагавраас /бусдын эд хөрөнгийг устгасан, гэмтээсэн гэх мэт/ шалтгаалан Эрүүгийн хуулийн аль тохирох зүйл, хэсгээр давхар зүйлчилж болно.

5.4. "Өс хонзон" гэдэгт хохирогчийн хэлсэн үг, хийсэн үйлдэлд гэмт этгээд өөрийнх нь үзэл бодол, үнэлэмжид нийцээгүй гэж дургүйцэн гомдож, түүнээс хариу авах, хорсол тайлах гэсэн санаа зорилгыг ойлгоно.

Энэхүү сэдэлт нь зөвхөн гэмт этгээд хохирогч хоёрын хоорондын харилцаанаас гадна үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, гаднах төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр буулин байдал, цусан өшөө зэргээс үүссэн байж болно. Харин хувийн таарамжгүй харьцааны улмаас хүнийг санаатай алсан бол өс хонзонгийн сэдэлтээр хүнийг санаатай алсан гэж үзэхгүй.

5.5. "Захиалгаар" гэж гэмт этгээд нь хэн нэгний хүсэлтээр, өөртөө болон бусдад эдийн ба эдийн бус ашигтай байдал бий болгох, эсхүл тодорхой бодлол бүхий амлалт авч хүнийг санаатай алсныг хэлнэ.

Энэ тохиолдолд захиалагчид Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.2, 37 дугаар зүйлийн 37.4-т заасныг журамлан тусгай



ангийн 91 дүгээр зүйлийн 91.2.4-т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Уг гэмт хэргийг үйлдэхэд хатгагч, хамжигч, зохион байгуулагч нар идэвхтэй хамтран оролцдогийг анхаарвал зохино.

5.6. "Хохирогчийн цус, эд, эрхтнийг ашиглах зорилгоор" гэдэгт хүний нөхөн үржихүйн эд /өндгөөч, төмсөг, өндгөн эс, сүн, ураг/-ээс бусад эд эрхтнийг болон цусыг өөртөө эсхүл бусдад хэрэглэх зорилгоор хүнийг санаатай алахыг ойлгоно.

Хэрэв уг гэмт хэргийг энэ зүйлд заасан бусад хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол мөн зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилнэ.

5.7. "Өөр гэмт хэргийг нуун далдлах буюу хялбарчлах зорилгоор" гэдэгт өөрийн болон бусдын үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж байгаа гэмт хэргийг гэрчлэх буюу мэдээлж болзошгүй, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд учирч болох саадыг арилгах, төгс үйлдэхэд шаардлагатай нөхцөл бүрдүүлэх гэсэн шалтгаанаар хүнийг алахыг хамааруулан үзнэ.

Энэ тохиолдолд гэмт этгээдийн үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж байсан, завдсан гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага мөн хүлээлгэнэ.

5.8. "Уулгалан довтлох буюу дээрэмдэх хэргийг үйлдэхдээ" гэж Эрүүгийн хуульд заасан эдгээр төрлийн гэмт хэргийг үйлдэх явцдаа хүнийг санаатай алсныг хэлнэ.

Уулгалан довтлох гэмт хэргийг үйлдэх явцад хүнийг санаатай алсан бол мөн хуулийн 180 дугаар зүйлийн 180.1-д зааснаар давхар зүйлчилнэ.

Харин бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг үйлдэх явцдаа хүнийг санаатай алсан бол энэ зүйл, хэсэгт зааснаар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд дээрмийн гэмт хэргээр давхар зүйлчлэхгүй.

5.9. "Хүн хулгайлах буюу бусдыг барьцаанд авах гэмт хэрэг үйлдэхдээ" гэдэгт эдгээр төрлийн гэмт хэргийг үйлдэх явцдаа хүнийг санаатай алсан байхыг ойлгоно. Энэ тохиолдолд гэмт үйлдлийг Эрүүгийн хуулийн 108, 112 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилнэ.

"Хүн хулгайлах" гэж хүнийг өөрийнх нь хүсэл зоригоос гадуур, нууц, далд аргаар эзэрхийлэн авч, өөрийн эрхшээлд оруулан, эрх, эрх чөлөөг нь хууль бусаар хязгаарлаж байгаа үйлдлийг хэлнэ.

"Барьцаанд авах" гэдэгт бусдаас мөнгө, эд хөрөнгө гаргуулах, эсхүл аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зэрэг болзол тавьж, хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учруулахаар заналхийлж, энэ тухайгаа хэн нэгэнд мэдэгдэн, шаардсан идэвхтэй үйлдлийг ойлгоно.

Хүн хулгайлах, хүнийг барьцаалах гэмт хэргийг үйлдэх явцад хүний амь насыг болгоомжгүйгээр хохироосон нь үүнд хамаарахгүй бөгөөд энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 108, 112 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

5.10. "Онц аюултай гэмт хэрэгтэн" гэдэгт шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээд хамаарна.

5.11. "Хүнийг санаатай алах гэмт хэргийг давтан үйлдсэн" гэдэгт хүнийг санаатай алсан буюу алахаар завдсан /санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчдасан үед бусдыг санаатай алах гэмт хэрэг хамаарахгүй/ гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн байхыг ойлгох бөгөөд үүндээ ял шийтгүүлсэн буюу шийтгүүлээгүйн аль аль нь хамаарна.

Энэ тохиолдолд гэмт этгээд хүнийг санаатай алах гэмт хэрэгт ямар байдлаар хамтран оролцсон нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Харин хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгуй болсон, ялгүйд тооцогдсон этгээдийн шинээр үйлдсэн гэмт хэрэг нь давтан үйлдсэн гэмт хэрэгт тооцогдохгүй.

5.12. "Бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоолд зааснаар ойлгож хэрэглэнэ.

5.13. "Онц харгис хэрцгий арга"-д хүнийг алахын өмнө буюу алах явцдаа хохирогчид олон тооны шарх, гэмтэл үүсгэж өвтгөн шаналгасан, тарчилган зовоосон, учруулсан гэмтлийн улмаас зовж зудрахээр байдал бий болгосон, ийм үйлчилгээ үзүүлэх бодис зориуд хэрэглэсэн, эсхүл өлсгөж цангаасан, осгоосон, амьдаар нь шатаан түлсэн, хайрсан, хохирогчийг тарчилгах зорилгоор түүнд бусдаас тусламж үзүүлэхэд санаатайгаар саад учруулсан, ойр дотнын хүмүүсийнх нь дэргэд алж тэднийг сэтгэл санааны хувьд хүндээр шаналгасан зэрэг үйлдлийг хамааруулна.

Гэмт этгээд нь үйлдсэн гэмт хэргээ нуун далдлахын тулд цогцсыг устгасан болон хэсэгчлэн хуваасныг онц харгис хэрцгий аргаар хүнийг санаатай алсан гэж үзэхгүй.

Харин гэмт этгээд амь хохирогчийг нас барсан болохыг мэдээгүй үедээ дээрх үйлдлийг хийсэн бол түүнд энэ зүйл, хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.



